

**САНГИЙН САЙД, МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 5 дугаар сарын 23

113/A-81//
Дугаар //46

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 111/A-105/131 тоот хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журам”-ын 1.12 дахь заалтыг хүчингүй болгосугай.
2. Журмын 1.8; 1.10; 1.11 дэх заалтуудыг дор дурдсанаар тус тус өөрчилсүгэй:

“1.8 Хэлцлийн төлбөр тооцоог арилжааны өдөрт /Т+0/ багтаан гүйцэтгэнэ”

“1.10 Цахим арилжааны системээр дамжин төлбөр тооцоо хийгдсэн ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн хэлцлийн мэдээллийг Монголбанк тухайн өдрийн 16:00 цагаас өмнө “ҮЦТТТХТ” ХХК-д цахим арилжааны системээр дамжуулан хүргүүлэх бөгөөд уг мэдээлэлд үндэслэн тухайн өдрийн 17:00 цагаас өмнө “ҮЦТТТХТ” ХХК өмчлөх эрхийг шилжүүлэн бүртгэл хийнэ.”

“1.11 “ҮЦТТТХТ ХХК” төлбөр тооцоо хийгдсэн ЗГҮЦ-ны хэлцлийн мэдээллийг төвлөрсөн хадгаламж дахь харилцагчийн мэдээлэлтэй тулгаж, мэдээлэл зөрсөн, эсвэл данс нээгээгүй байх, хэлцлээр худалдаж буй ЗГҮЦ-ны эзэмших эрхийн маргаантай тохиолдолд Монголбанкинд тухай бүр мэдэгдэнэ.”

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газар (Б.Нямаа), Монголбанкны Валют, эдийн засгийн газар (Д.Дэлгэрсайхан), Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар), Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (М.Амгалан), Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газар /Б.Саруул/, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв /Т.Гандулат/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Б.Батцэцэг), Монголбанкны Дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн газар (Х.Дэлгэр), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ

САНГИЙН
САЙД

Ч.УЛААН

САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН